

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202.. оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүл зүйн хараат бус, байдлыг хангах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох замаар олон ургальч, хариуцлагатай хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд оршино.

##### 2 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Радио долгионы тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай, Зар сурталчилгааны тухай, Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай болон бусад хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн нийгэмд нөлөө үзүүлж буй үйл явдал, үзэгдэл, мэдэгдэл, бодлого, төлөвлөгөө, шийдвэр зэргийн талаар **олон нийтийн эрх, ашиг сонирхолын төлөө** тодорхой бүлэг, салбар эсхүл нийгэмд бүхэлд нь мэдээлэл өгөхийн тулд үйл явдлыг ажиглаж, тодорхойлон тайлбарлаж, дүн шинжилгээ хийж, баримтжуулан уг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хараат бус, ил тодоор **хэвлэн нийтлэх үйл ажиллагаатай холбоотой** харилцааг зохицуулна.

3.2.Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцид хамаарахгүйгээр бие даан сэтгүүл зүйн үйл ажиллагаагаа гүйцэтгэж байгаа этгээдийн аль нэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн бүтээл, түүнтэй холбоотой харилцаа нь энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“сэтгүүлч” гэж олон нийтийн эрх ашиг сонирхлын төлөө мэдээ, мэдээлэл бэлтгэх, цуглуулах, засварлах, нягтлах, агуулга бүтээх зэрэг чиг үүргийг

тодорхой хэвлэл мэдээллийн байгууллагын редакцид хамааран орон тооны болон орон тооны бус байдлаар гүйцэтгэж байгаа редакцын эрхлэгч, сурвалжлагч, зураглаач, фото сурвалжлагч, тоймч, тайлбарлагч, мэдээний найруулагч, хөтлөгч, эвлүүлэгч зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнууд эсхүл бие даан чөлөөт байдлаар сэтгүүлзүйн үйл ажиллагааны гүйцэтгэж байгаа хүнийг;

4.1.2.“сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэж олон нийтэд мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх, татан оролцуулах зорилгоор мэдээ мэдээлэл хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нягтлах үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, нэвтрүүлэх, түгээх мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.3.“худал мэдээлэл” гэж бусдын сэтгэл санаа, бие махбодь, эсхүл бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулах зорилгогүйгээр түгээсэн бодит байдалд үл нийцэх алдаатай мэдээллийг;

4.1.4.“илт худал мэдээлэл” гэж бодит үйл явдалд тулгуурласан боловч тухайн үйл явдлыг хэт дэвэргэх, буруу ойлголт төрүүлэхээр зориуд дутуу, эсхүл зарим хэсгийг тасалж авч мэдээлэх эсхүл бодит үйл явдал болсон мэтээр зохиож ор үндэслэлгүй худал мэдээллийг хувь хүн, хуулийн этгээд, байгууллага, улс оронд санаатайгаар хохирол учруулах зорилгоор түгээсэн мэдээллийг

4.1.5.“хэвлэл мэдээллийн байгууллага” гэж редакцын шийдвэрээр мэдээлэл хайх, цуглуулах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх, түгээх зэрэг сэтгүүл зүйн үйл ажиллагаа тогтмол эрхэлдэг, сонин, сэтгүүл, радио, телевиз, редакцтай сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг хуулийн этгээдийг;

4.1.6.“хэвлэл мэдээллийн байгууллагын редакц” гэж хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, бодлогыг тодорхойлох, бүтээх, редакторлох үйл ажиллагааг зохион байгуулж байгаа нэгж, хүнийг;

4.1.7.“хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийг олон нийтэд, эсхүл тодорхой бүлэг этгээдэд хүргэх, түгээх зорилгоор ашиглаж байгаа сонин, сэтгүүл, радио, телевиз, редакцтай мэдээллийн сайтыг;

4.1.8.“хүйн хэвлэл мэдээллийн байгууллага” гэж зөвхөн тодорхой орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, тухайн орон нутгийн соёл, зан заншил, онцлог байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, түгээх зорилготой, орон нутгийн иргэдээс үүсгэн байгуулж, эзэмшиж, удирдаж байгаа, ашгийн бус, хараат бус хэвлэл, мэдээллийн хэрэгслийг

4.1.9.“эх сурвалж” гэж сэтгүүлчийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээллийн үндэслэл болж байгаа үйл баримт, мэдээллийг өгч байгаа этгээдийг;

4.1.10.“эх сурвалж нууцлах эрх” гэж хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлч нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалж, мэдээллийг дамжуулсан арга хэрэгслийг гуравдагч этгээдэд илчлэхгүй байхыг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙДЛЫН БАТАЛГАА**

#### **5 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах баталгаа**

5.1. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль, захиргааны хэм хэмжээний акт батлахыг хориглоно.

5.2. Хэвлэн нийтлэх эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулсны төлөө нийгмийн сүлжээнд өөрөө хэвлэн нийтлэгч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг төрөөс аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, хэвлэн нийтлэх бүтээлд агуулгын хяналт тогтоохыг хориглоно.

5.3. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд агуулгын хяналт тавих байгууллага, албан тушаал бий болгохгүй бөгөөд ийм үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглоно.

5.4. Хуульд өөрөөр заагаагүй бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн байгууллага өөрийн үйл ажиллагаагаа тусгайлан сурталчлуулах, үнэ төлбөргүй мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхийг шаардахыг хориглоно.

5.5. Монгол Улсын тухай албан ёсны мэдээллийг олон улсад түгээх, сурталчлах зорилго бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллана. Энэ хэсэгт заасан хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд улсын хэмжээнд нэгээс илүүгүй байж Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд үйл ажиллагаагаа явуулна.

5.6. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад шийдвэрийн төсөлд санал авах, батлагдсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг олон нийтэд сурталчлах болон энэ хуулийн 5.5-д зааснаас бусад зорилгоор төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн байгууллага ажиллуулахыг хориглоно.

5.7. Төрийн байгууллага, албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд нь хэвлэл мэдээллийн байгууллагыг үйл ажиллагаагаа бие даасан, хараат бусаар эрхлэхэд саад учруулах, энэ хуульд зааснаас бусад тохиолдолд сэтгүүлчийг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардахыг хориглоно.

5.8. Хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн байгууллага, албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд нь хэвлэл мэдээллийн байгууллагыг үйл ажиллагаагаа бие даасан, хараат бусаар эрхлэхэд саад учруулах, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг албадан зогсоох, татан буулгахыг хориглоно. Төрийн байгууллага нь хэвлэл мэдээллийн байгууллагын түгээсэн мэдээ мэдээллийн эсрэг шүүхэд гомдол гаргахгүй бөгөөд алдаатай мэдээлэл түгээсэн гэж үзсэн бол залруулга, тодруулга хийнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “агуулгын хяналт” /цензур/ гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх мэдээллийн агуулгыг урьдчилж хянах, хөндлөнгөөс нөлөөлөх аливаа үйл ажиллагааг ойлгоно.

## **6 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах эрх**

6.1. Монгол Улсын иргэн бүр үндэс, угсаа, хэл, соёл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг баримжаа, ял шийтгүүлсэн байдлыг үл харгалзан үзэл бодлоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх, хуульд заасан журмын дагуу хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, эрхлэх эрхтэй.

6.2.Хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, бүртгэхтэй холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

### **7 дугаар зүйл.Редакцын хараат бус байдлын баталгаа**

7.1.Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бусаар, чөлөөтэй эрхэлнэ.

7.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, бодлогыг тодорхойлох, бүтээх, редакторлох үйл ажиллагааг зохион байгуулах рөдөцтэй байна.

7.3.Редакц нь төр, өмчлөгч, ивээн тэтгэгч, улс төрийн байгууллагын хөндлөнгийн оролцоогүйгээр сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагааг бие даан явуулна. Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, хувь хүн хэн боловч редакцын мэргэжлийн үйл ажиллагаа, нийтлэлийн бодлогод хөндлөгөөс нөлөөлөхийг хориглоно.

7.4.Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц нь нийтэлж, нэвтрүүлж буй бүтээлийн агуулгын үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

7.5.Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч нь редакцтай сэтгүүл зүйн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах талаарх гэрээ байгуулах бөгөөд энэ талаар байгууллагын дотоод журамд тусгана.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан дотоод журамд редакц, сэтгүүлчийн мэргэжлийн хараат бус байдлыг хангах, ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх асуудлыг тусгана.

7.7.Хэвлэл мэдээллийн байгууллага нь санхүүгийн хараат бус байдлаа хангах зорилгоор мэргэжлийн ёс зүй хэм хэмжээнд харшлахгүй, хуулиар хориглоогүй зар сурталчилгаа, бусад аж ахуйн орлогын эх үүсвэртэй байж болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ**

### **8 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллага**

8.1.Хэвлэл мэдээллийн байгууллагыг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус зорилготой байна.

8.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтийн, хүйн болон арилжааны төрөлтэй байна.

8.3.Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулна.

8.4.Энэ хуулийн 4.1.7-д заасан хүйн хэвлэл мэдээллийн байгууллагаас бусад хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн төлөө зорилготой, компани хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

8.2.Энэ хуулийн 8.4-т заасан хуулийн этгээдийн бүртгэл, зохион байгуулалттай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

## **9 дүгээр зүйл.Хүйн хэвлэл мэдээллийн байгууллага**

9.1.Олон ургальч байдлыг дэмжих, иргэдийн оролцоог хангах, орон нутгийн онцлог байдлыг илэрхийлэх зорилгоор тодорхой орон нутгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг, тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулж, эзэмшдэг хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллаж болно.

9.2.Энэ хуулийн 9.1-т заасан хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь зөвхөн тухайн орон нутагтай хамааралтай мэдээ, мэдээлэл түгээж, иргэдийн оролцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа хараат бусаар явуулна.

9.3.Арилжааны радио, телевиз байгуулахад тавигдах техникийн үзүүлэлт, хүний нөөц, нэг өдрийн нэвтрүүлгийн доод хугацаа, орлого зэрэг шаардлагаас хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг чөлөөлнө.

9.4.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.1-т заасан тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нөхцөл нь хүйн хэвлэл мэдээлэлд хамаарахгүй.

## **10 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаандаа баримтлах зарчим**

10.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтийн эрх ашгийг хүндэтгэж дараах зарчмыг баримталбал зохино:

10.1.1.хүн төрөлхтний үнэт зүйл, ардчилал, шударга ёс, тэгш байдлыг хүндэтгэх;

10.1.2.бусдын эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг хүндэтгэх;

10.1.3.гэмт хэрэг, зөрчил, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зан суртахуунд харшилсан үйлдлийг сурталчлахгүй байх;

10.1.4.сэтгүүл зүйн үйл ажиллагаагаа эрхлэхдээ улс төр, санхүүгийн нөлөөлөл болон төрийн байгууллага, аж ахуй эрхлэгчийн хууль бус нөлөөллөөс ангид байх.

10.1.5.судалгаа, баримттай тэнцвэртэй, шударга ёсны зарчимд нийцүүлэн олон талын байр суурийг илэрхийлэх цогц байдлаар мэдээллийг дамжуулах;

10.1.6.хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйг баримталж, алдаа гаргасан бол залруулга хийдэг байх;

10.1.7.олон нийтэд мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх, нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг байх;

10.1.8.хууль дээдлэх, бусдын оюуны өмч, зохиогчийн эрхийг хүндэтгэх;

10.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь бодит мэдээлэл, баримтад тулгуурласан мэдээллийг түгээх бөгөөд энэ хуулийн 10.3-т зааснаас бусад тохиолдолд өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

10.3.Ил мэдээлсэн эх сурвалжийн мэдээлэл, үзэл бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулсан, нийтэлсэн, нэвтрүүлсэн бол энэхүү мэдээллээс үүсэх хариуцлагыг тухайн ил мэдээлсэн эх сурвалж хариуцна.

10.4.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн–нийтэд түгээсэн мэдээллийг худал мэдээлэл байсан гэж үзвэл эрх нь хөндөгдсөн этгээд гомдлоо редакц, энэ хуулийн 15.1-д заасан хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагад гаргаж болно.

10.5.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь тодорхой мэдээлэл нийтэлж, нэвтрүүлэхээр бусдыг сүрдүүлэх, дарамт үзүүлэх, нийтэлсэн болон нийтлээгүйн төлөө шан харамж авах, ийм оролдлого хийхийг хориглоно.

10.6.Хэвлэл мэдээллийн байгууллага нь захиалгат, эсхүл төлбөртэй нийтлэл, нэвтрүүлэг хүргэхдээ захиалгат, эсхүл төлбөртэй болохыг тодорхой илэрхийлэх тэмдэглэгээ хэрэглэж, захиалагчийн, эсхүл төлбөр төлсөн этгээдийн нэр, нэвтрүүлэг бэлтгэсэн сэтгүүлч, уран бүтээлчийг дурдана.

## **11 дүгээр зүйл.Редакцад гомдол гаргах**

11.1.Хувь хүн, хуулийн этгээд нь хэвлэн нийтлэгдсэн худал мэдээллийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзвэл хэвлэл мэдээллийн байгууллагын редакц, эрх бүхий удирдах албан тушаалтанд бичгээр гомдол гаргах эрхтэй.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан гомдлыг хүлээж авсан этгээд нь гомдлыг шалгаж үзээд үндэслэлтэй бол худал мэдээллийн талаар залруулга хийх үүрэгтэй.

11.3.Энэ хуулийн 11.2-т заасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл бие даан үйл ажиллагаа явуулдаг этгээдийн хэвлэн нийтэлсэн худал мэдээллийн талаарх гомдлыг энэ хуулийн 15.1-д заасан хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагад дүгнэлт гаргуулахаар гаргаж болно.

11.4.Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан нөхцөл нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болон шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй.

## **12 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн ил тод байдлыг хангах**

12.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь эзэмшлийн талаарх дараах мэдээллийг олон нийтэд ил тод зарлана:

12.1.1.хуулийн этгээдийн нэр, таван хувиас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

12.1.2.хэвлэл мэдээллийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

12.1.3.редакцын нийтлэлийн бодлого;

12.1.4.холбоо барих мэдээлэл (редакцын хаяг, утас, цахим шуудангийн хаяг).

12.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 12.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг шинэчилнэ.

12.3.Энэ хуулийн 12.1.1-т заасан этгээд нь хэвлэл мэдээллийн байгууллага дахь хувь эзэмшлээ нуун дарагдуулах, бусдын нэрийг ашиглан улсын бүртгэлд хуурамчаар бүртгүүлэхийг хориглоно.

12.4.Хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүгийн тайлан нь олон нийтэд нээлттэй байна.

### **13 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс сэргийлэх**

13.1.Хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөөн, олон ургальч үзлийг дэмжих зорилгоор хүн, хуулийн этгээд хэд хэдэн сонин хэвлэл, телевиз, радио сүлжээ, цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн платформыг эзэмших байдлыг хязгаарлаж болно.

13.2.Хэвлэл мэдээллийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх, хязгаарлалт тогтоох, үнэлгээ дүгнэлт гаргах, бүртгэхтэй холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

13.3.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний өмчлөгч нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг зүй бусаар хязгаарласан, редакцын хараат бус байдалд халдсан, хэвлэл мэдээллийн салбарт өрсөлдөөнийг хязгаарласан аливаа үйлдэл гаргах, монополь, давамгайл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖАА НУУЦЛАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ**

### **14 дүгээр зүйл.Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хамгаалах**

14.1.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй.

14.2.Тухайн мэдээллийн нууцалсан эх сурвалжийг өөр арга замаар олж мэдэх боломжгүй бөгөөд үндэсний аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндэд бодит хохирол учруулахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эх сурвалжаа нууцлах эрхийг тус шүүхийн шийдвэрээр хязгаарлаж болно.

14.3.Төрийн байгууллага, албан тушаалтан, бусад этгээд сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад учруулах, хуульд зааснаас бусад үндэслэлээр сэтгүүлчийг мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхийг шаардахыг хориглоно.

14.4.Сэтгүүлчийн мэдээллийн эрх сурвалжаа нууцлах тодорхой тохиодол нь Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийн 4.1.2-т заасан үйл ажиллагаанд хамаарах бол түүнийг мөн хуулийн 4.1.1-т заасан этгээд гэж үзнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **15 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалт**

15.1.Хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалтын байгууллага байгуулж болно. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага нь бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаагаа бие даан шийдвэрлэнэ.

15.2.Хэвлэлийн мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баталж, уг ёс зүйн хэм хэмжээг редакц, сэтгүүлчийн нийтлэл, нэвтрүүлэг зөрчсөн талаарх хүн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг үнэ төлбөргүй хүлээн авч, хянан хэлэлцэж болно.

15.3.Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага энэ хуулийн 15.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн эсэх талаар мэргэжлийн дүгнэлтийг хамтын зарчмаар гаргаж, шийдвэрийг нээлттэй мэдээлнэ.

15.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эрх бүхий этгээд нь редакц, сэтгүүлчийн эсрэг гомдлыг хянан шийдвэрлэх явцдаа түүнийг мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчилтэй холбоотой эсэхийг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагаар урьдчилан дүгнүүлж болно.

15.5.Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 15.2-т заасан сэтгүүл зүйн үйл ажиллагааны ёс зүйн хэм хэмжээг редакцын үйл ажиллагаандаа мөрдүүлэх үүрэг хүлээнэ.

#### **16 дугаар зүйл.Сэтгүүлчийн эвлэлдэн нэгдэх эрх**

16.1.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн харьяалал болон бусад ашиг сонирхлоор эвлэлдэн нэгдэж ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулж болно.

16.2.Сэтгүүлчийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий хэвлэл мэдээллийн ажилтнуудын үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулж болно.

16.3.Энэ хуулийн 16.1-16.2-т заасан байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуульд зааснаар зохицуулна.

### **ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **17 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

17.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан, энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

#### **18 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

18.1.Энэ хуулийг.....оны.....дугаар сарын...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг